



**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/213

Улиастай

┌ Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа ┐  
эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2; Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2; Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.11, 19.18, 19.20.1, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн ажлын хэсгийн хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын тусгай зөвшөөрлийн хугацааг шинээр олгох, сунгах, хүчингүй болгох, шинжээч ажиллуулах байгууллагуудын нэрсийг хавсралтаар баталсугай.


2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, сунгасан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс /Л.Лхамсүрэн/-т үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байгууллагын үйл ажиллагааг зогсоож, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /А.Даваадорж/, тусгай зөвшөөрлийг сунгасан, олгосон байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ч.Дэмчигсүрэн/-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /А.Шаравжамц/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс /Н.Бямбадорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТСАЙХАН



Захирамж 2019

811190740

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын  
27-өдрийн 86 дугаар захирамжийн хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах байгууллага

д/д	Байгууллагын нэрс	Дууссан хугацаа	Сунгасан хугацаа
1	Цагаан чулуут сумын Эмийн эргэлтийн сан	2019.06.10	5 жил
2	Цэцэн уул сумын Эмийн эргэлтийн сан	2019.05.28	5 жил
3	Шилүүстэй сумын Эмийн эргэлтийн сан	2019.06.10	5 жил
4	Ургамал сумын Эмийн эргэлтийн сан	2019.06.26	5 жил

Тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн байгууллага

д/д	Байгууллагын нэрс	Олгосон хугацаа	Дуусах хугацаа
1.	Их уул сумын Элбэг эмийн сан	3 жил	2022
2.	Улиастай Жавцаг мед хувийн эмнэлэг	3 жил	2022
3.	Улиастай Гэгээн тус хувийн эмнэлэг	3 жил	2022

Шинжээч ажиллуулахаар шийдвэрлэсэн байгууллагуудын нэрс:

д/д	Байгууллагуудын нэр	Харъяалал
1.	Гурван эрдэнэ хувийн эмийн сан	Их-Уул сум
2.	Гал чацаргана хувийн эмийн сан	Тосонцэнгэл сум
3.	Дотрын үүдэн эмнэлгийн төсөл	Сонгино сум

Тусгай зөвшөөрлийг цуцлахаар шийдвэрлэсэн байгууллага:

д/д	Байгууллагын нэр	Хугацаа дууссан	-
1.	Монос завхан ХХК-ны эмийн сан	2019.03.26	-